

ЭЗБШӨЧ ТӨСЛИЙН САР ТУТМЫН ЦУВРАЛ

2008 оны 10, 11 дүгээр сар

Монголын Компанийн засаглалын чуулган эхэллээ

10 дугаар сарын 8-ны өдөр Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн бирж, Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимаас зохион байгуулсан Компанийн засаглалын чуулганы ажиллагаанд төслөөс дэмжлэг үзүүлэв.

Уг чуулганд компанийн засаглалын өнөөгийн байдал, санхүүжилт олж авахад сайн засаглал, ил тод байдал, нээлттэй тайлагналын ач холбогдлын талаар төвлөрч ярилцсан бөгөөд нийт 37 төлөөлөгчид, үүний дотор хөрөнгийн биржид бүртгэлтэй томоохон компаниудын удирдах ажилтнууд оролцсон юм.



Чуулганд илтгэл тавьсан “Зоос” банкны Гүйцэтгэх захирал Ш. Чуданжий тус банкнаас баталж хэрэгжүүлж буй компанийн засаглалын кодекс, үүнийг баримталснаар тус банкны ажиллагаа хэрхэн сайжирч, ашиг нэмэгдсэн тухай ярилаа. Тэрбээр “Зоос” банкны зүгээс компанийн засаглалын кодексыг хэрэгжүүлснээр нийгмийн хариуцлага, дотоод хяналтын ажиллагаа, ил тод байдал, нээлттэй тайлагнал, хувьцаа эзэмшигчдэд эрх тэгш хандах хандлага сайжирсныг онцлон тэмдэглэв. Тус банк ёс зүйн менежментийн удирдлагын бодлогыг хэрэгжүүлснээр Монгол улсад компанийн засаглалыг нэвтрүүлсэн манлайлагч болж, бизнесийн бусад байгууллагуудад үлгэр жишээ болж байна.

Түүнчлэн Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д. Баярсайхан Монгол улс дахь компанийн засаглалтай холбоотой зохицуулалтын бодлогын үр нөлөө, тус газраас компанийн засаглалтай холбоотой дүрэм журмыг сайжруулах, тэдгээрийг дагаж мөрдүүлэх талаар хийж буй ажлынхаа талаар танилцууллаа. 2007 онд гаргасан компанийн засаглалын кодекс нь Монгол улсын хувьд компанийн засаглалын үйл ажиллагаа, стандартыг тодорхойлох дүрэм журмуудыг боловсруулах үндэс болж байна.

Монголын Хөрөнгийн биржийн бүртгэл, хяналтын газрын дарга Ц. Цэндмаа Монголын хөрөнгийн бирж дэх хувьцааны үнийн хандлагад нөлөөлөх ил тод, нээлттэй тайлагналын үр нөлөөний талаар илтгэл тавилаа. Тус биржид нийтдээ 380 компанийн үнэт цаас арилжаалагдаж байгаа бөгөөд эдгээрийн 95 гаруй хувийг томоохон хөрөнгө оруулагчид хянаж байна. Хувьцааны дийлэнх нь хөрөнгийн зах зээлд идэвхтэй арилжаалагдаж чадахгүй байгаагаас тэдгээрийн үнийг бодитойгоор тогтооход хүндрэл учирч байна. Түүний үзэж байгаагаар мэдээллийн ил тод байдалтай холбоотой эрх зүйн болон зохицуулалтын орчин хангалттай биш байна. Тиймээс хөрөнгийн биржид бүртгэлтэй бүх компанийн ил тод, нээлттэй байдлыг хангах нь хөрөнгийн биржид үнэ тогтоох ажиллагааг сайжруулахад онцгой үр нөлөө үзүүлэх болно гэлээ.

Компанийн засаглалын олон улсын зөвлөх доктор Дэмир Енэр Монгол улсад хэрэгжиж буй компанийн засаглалд хийсэн үнэлгээнийхээ талаар танилцуулж, Монгол улс нь хэдийгээр компанийн засаглалын орчин үеийн кодексыг нэвтрүүлсэн боловч мөрдөж хэрэгжүүлж буй байдал нь олон улсын шилдэг туршлагаас ихээхэн зөрж байна гэж дүгнэлээ. Иймд тулгамдсан дараахь асуудлуудыг шийдвэрлэх ёстой юм. Үүнд:

- Хувьцаа эзэмшигч цөөнхөд шударга бус хандаж байна
- ТУЗ сул, үр дүн муутай ажиллаж байна
- Ил тод байдал, нээлттэй тайлагнал зохих ёсоор ажиллуулж чадахгүй байна.

Дээрх доголдлыг арилгах аливаа арга хэмжээг хэрэгжүүлэхэд дараахь асуудалд анхаарлаа хандуулах шаардлагатай:

- Компанийн засаглалын практик ажиллагааг дэмжиж, мөрдүүлэхийн тулд институцийн хүчин чадлыг сайжруулах
- Захирлуудын зүгээс үүрэг хариуцлагаа ойлгох, чиг үүргээ хэрэгжүүлэхэд туслахын тулд тэдний чадавхийг дээшлүүлэх
- Хувьцаа эзэмшигчдийн эрхийн тухай ойлголтыг сайжруулах, нээлттэй, шударга хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулах асуудлаар олон нийтийн боловсролыг дээшлүүлэх.

Чуулганд оролцогчид, илтгэл тавьсан хүмүүсийн дунд өрнөсөн нээлттэй, илэн далангүй ярилцлагын дараа Монгол улсад компанийн хамгийн шилдэг засаглалыг нэвтрүүлэх ажиллагааг дэмжих чиглэлд цаашид авах арга хэмжээний талаар хамтарсан мэдэгдэл гаргах нь зүйтэй гэдэгтэй санал нэгдсэн юм. Оролцогчдын зүгээс мөн жил бүр Компанийн засаглалын чуулган (КЗЧ)-ыг зохион байгуулах нь зүйтэй гэж үзлээ. Хэрэв компанийн засаглалыг хэрэгжүүлж буй томоохон компаниуд болон шинэчлэгчдийн хуанлид уг чуулганыг “заавал оролцох ёстой” үйл явдал гэж тэмдэглэсэн бол уг арга хэмжээ амжилттай хэрэгжих буйг харуулах нэг үзүүлэлт болох юм.

Замын-Үүдийн Логистик паркийг төр-хувийн хэвшлийн түншлэлийн компани хэлбэрээр байгуулахыг зөвлөмж болголоо




Монгол Улсын Засгийн газрын хүсэлтээр төслийн зүгээс 2008 онд хил орчмын ачаа тээврийн хөдөлгөөнийг сайжруулах, Замын-Үүд дэх логистик паркийг барьж байгуулахтай холбоотой зөвлөмж гаргах зорилгоор техник, эдийн засгийн хэд хэдэн судалгаа хийлээ. Эдгээрийн нэг зөвлөмж нь импортын баримжаатай орчин үеийн логистик паркийг барьж,

Харин хувийн хэвшил нь бүтээн босголтын хөрөнгө оруулалт хийх юм.

ЛПХК нь төслийн менежер, санхүү, аж ахуйн ажилтнаас бүрдсэн цөөн тооны ажилтантай хувьцаат компани байх юм. Логистик паркийн талбайд холбогдох байгууламжуудыг барих, үйл ажиллагааг нь явуулах байгууллагыг өрсөлдөөнт сонгон шалгаруулалтаар шалгаруулж, Логистик паркийн бүтээн босголт, үйл ажиллагааны менежментийн урт хугацааны гэрээ байгуулсан гүйцэтгэгч байгууллагаар дамжуулан дээрх ажлуудыг хийж гүйцэтгэхээр төлөвлөж байна.

Логистик паркийг тодорхой үе шаттайгаар байгуулж ажиллуулна. Логистик паркийн эхний шатны бүтээн босголтын ажлыг 2011 он гэхэд гүйцэтгэж дуусна гэж үзэж байгаа бөгөөд энэ шатанд автозамаас төмөр замд шилжүүлэн ачих орчин үеийн талбай/байгууламж, ачаа барааг төрөлжүүлэн нэгтгэх байгууламж, агуулах, нэмүү өртөг шингэсэн логистик үйлчилгээ, тухайлбал шатахуун түгээх газар, засвар үйлчилгээний газар, жолооч нарт зориулсан хоолны газар, зочид буудлыг барихаар төлөвлөж байна. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх эхний шатны зорилтуудын хүрээнд дараахь ажлуудыг хийж гүйцэтгэх юм. Үүнд:



ажиллуулах үүрэг бүхий төр-хувийн хэвшлийн түншлэлд суурилсан Логистик паркийн хөгжлийн корпораци (ЛПХК)-ийг байгуулахыг зөвлөсөн байсан юм. ЭЗБШӨЧ төслөөс дээрх техник эдийн засгийн судалгааны үр дүнг Ерөнхий сайдын дэргэдэх Монгол дахь хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, хувийн хэвшлийг хөгжүүлэх зөвлөлдөх зөвлөлд танилцуулж, төр-хувийн хэвшлийн түншлэлийн бүтцийн талаар зөвлөсөн бөгөөд энэ дагуу тус Зөвлөлөөс зөвлөмж гаргаж, төр-хувийн хэвшлийн түншлэлийн хамтарсан хуулийн этгээдийг үүсгэн байгуулах чиглэлд Монголын Тээвэр зуучдын холбоо (МТЗХ)-той хамтран ажиллахыг Сангийн сайд, Төрийн өмчийн хорооны дарга нарт санал болгон тогтсон юм.

ЭЗБШӨЧ төсөл нь санал болгож буй ЛПХК-ийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, үүний дотор төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний графикт хугацаа, санхүүжилтийн хэрэгцээ шаардлагын талаар ярилцах зорилгоор Монголын тээвэр зуучдын компаниудтай 11 дүгээр сарын 7-ны өдөр уулзалт хийлээ. Санал болгож буй ЛПХК-ийг Монгол Улсын Засгийн газар (МУЗГ), тээвэр зууч, логистикийн салбарын хувийн хэвшлийн оролцоотой төр-хувийн хэвшилд суурилсан хувьцаат компани хэлбэрээр үүсгэн байгуулахаар төлөвлөж байна. Энэ хувилбарын дагуу МУЗГ нь Логистик паркийг барих газрыг урт хугацаагаар ашиглуулах эрхээр хангасныхаа төлөө тус корпорацийн хувьцааны 25 орчим хувийг эзэмшинэ.

- Замын-Үүдэд байгуулах Логистик паркийн урт хугацааны мастер төлөвлөгөөг боловсруулах, үүнд автозамаас төмөр замд шилжүүлэн ачих, ачааг төрөлжүүлэн нэгтгэх, дагалдах үйлчилгээний байгууламжийг барих ажил орно.
- Эхний шатанд өөрөө өөрийгөө санхүүжүүлэх чадвартай байгууламжууд, үүний дотор автозамаас төмөр замд, автозамаас автозамд шилжүүлэн ачих байгууламжийг барьж ажиллуулах
- Одоогийн ажиллаж буй УБТЗ-ын автозамаас төмөр замд шилжүүлэн ачих байгууламжийн үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх богино хугацааны хөтөлбөр хэрэгжүүлж, автозам, автомашины зогсоолын талбайг засч сайжруулах, механик аргаар ачих төхөөрөмжийг нэмэгдүүлж, ашиглалтыг сайжруулах

Хэрэгжилтийн төлөвлөгөөний эхний шатны ажлыг дараахь хуваарийн дагуу хийж гүйцэтгэнэ. Үүнд:

2008 оны 4-р улирал – Зохион байгуулалтын асуудлууд:

- Монгол Улсын Засгийн газар, Монголын Тээвэр зуучдын холбоо, хувийн хэвшлийнхний хооронд Харилцан ойлголцлын санамж бичиг, Үүсгэн байгуулагчдын гэрээг байгуулж гарын үсэг зурах
- ЛПХК-ийг үүсгэн байгуулах
- МТЗХ-ны эхний санхүүжилт

- Төслийн менежерийг ажилд томилох
- Зөвлөхүүдийг сонгох.

2009 оны 1-2-р улирал – Шинэ байгууламжуудын төлөвлөлт:

- Мастер төлөвлөгөө боловсруулах, мөн эхний шатанд хийж гүйцэтгэх ажлын баримжааг гаргахын тулд санхүүжигдэх боломжтой техник эдийн засгийн судалгааг хийж дуусгах
- ЛПХК-ийн санхүүгийн бүтцийг эцэслэн тогтоож хувийн хэвшлийн санхүүжилтийг оруулах
- ЛПХК-ийн нэрийн өмнөөс Логистик паркийг барьж байгуулах, үйл ажиллагааг нь хянах үүрэгтэй Логистик паркийн менежментийн компанийг сонгож, ажиллуулах.

2009 оны 1-2-р улирал – Одоогийн ашиглаж буй байгууламжийг сайжруулах ажил:

- БНХАУ-ын эрх бүхий байгууллага, Монгол Улсын Гаалийн албаны хооронд ачааг төрөлжүүлэн нэгтгэх, даац хэтэрсэн машиныг хориглох талаар тохиролцож, мөрдлөг болгох
- Автозамын сүлжээ, зогсоолын талбай, ачиж буулгаж хэрэгслийн механикжилтийг сайжруулах.

2009 оны 2-3-р улирал – ЛПХК нь юуны өмнө дараахь ажлыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- Санхүүжигдэх боломжтой техник эдийн засгийн судалгааг судалж хянах
- Үндсэн дэд бүтэц, нийтийн эзэмшлийн байгууламжуудын зураг төслийг боловсруулах, барилгын ажлын гэрээ байгуулах
- Франчайзын үйлчилгээ явуулах байгууламжуудын барилгын ажил, үйл ажиллагааны тендерийг зарлах
- Түр хугацааны байгууламжуудыг ажиллуулах.

2009 оны 4-р улирал – 2011 оны 2-р улирал – Эхний шатны ажлыг дуусгах:

- Үндсэн дэд бүтэц, нийтийн эзэмшлийн байгууламжуудыг барих
- Франчайзын үйлчилгээний байгууламжуудыг барих
- 1-р шатны байгууламжуудыг ашиглалтад оруулах
- Тур хугацааны байгууламжуудыг хаах.

2011 оны 1-2-р улирал – 2-р шатны ажлын төлөвлөлт:

- 1-р шатанд барьсан байгууламжуудыг өргөжүүлэх боломжийг судалж үнэлгээ хийх
- Төмөр замаас төмөр замд шилжүүлэн ачих байгууламжийг өөр талбайд байршуулах боломжийг судалж үнэлгээ хийх.

Урьдчилсан тооцоогоор санхүүжилтэд 300,000 ам.доллар шаардлагатай байгаа бөгөөд үүнийг санхүүжигдэх боломжтой техник эдийн засгийн судалгаа, төслийн удирдлагын зардалд зарцуулах юм. Үүнийг 250,000 ам.долларыг МТЗХ-ноос санхүүжүүлж, энэ төлбөрийг эргээд хөрөнгийн орлого эсхүл хувьцаагаар тооцож төлөхийг санал болгож байна. Харин үлдэх 50,000 ам.долларыг ЭЗБШӨЧ төслөөс гаргах бөгөөд энэ нь техник эдийн засгийн судалгааг хамтран санхүүжүүлэхэд зориулагдана.

11 дүгээр сарын 7-ны өдөр болсон уулзалтын үеэр Монголын Тээвэр зуучдын холбоо нь Засгийн газар, хувийн хэвшлийн хооронд ТХХТ-ийн талаар харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурах хүртэлх хугацаанд энэ чиглэлд үйл ажиллагаа явуулах ажлын хэсэг байгуулах тухай Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурахаар шийдсэн юм.

ЭХЗГ зах зээлийн ерөнхий загварын талаар эрчим хүчний компаниудтай ярилцаж тохиров

Тус төслийн дэмжлэгтэйгээр боловсруулсан "Монгол улсын Төвийн эрчим хүчний системийн (ТЭХС) цахилгааны өрсөлдөөнт зах зээлийн загвар" –ын талаар салбарынхнаа саналыг авах зорилгоор ЭХЗГ-аас энэ оны 11 дүгээр сард хэд хэдэн уулзалт зохион байгуулжээ. Уулзалтанд оролцогсодтой энэхүү загварын талаар санал солилцож, тэдний саналуудыг нэгтгэсний эцэст уг загварыг хэрэгжүүлэхэд ЭХЗГ бэлэн буйгаа илэрхийлэв.



Тусгай зөвшөөрөл эзэмшигчид санал болгож буй зах зээлийн ерөнхий загварыг санал нэгтэй дэмжиж ЭХЗГ болон ЭЗБШӨЧТ-өөс зах зээлийн ерөнхий загварыг дахин авч үзэх, өөрчлөхөд хүргэсэнгүй. Оролцогсдын тодруулахыг хүсч байсан зарим асуудлууд Зах зээлийн дүрэм ба Нэгдсэн системийн журмыг боловсруулах явцад шийдвэрлэх дэлгэрэнгүй асуудлууд байв. Санал болгож буй зах зээлийн ерөнхий загварыг хэрэгжүүлснээр:

- Хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээний чанар сайжирч, цахилгаан станцуудын өрсөлдөх чадвар дээшлэнэ
- Нүүрсний өртөг зардал буурч, агаарын бохирдол багасч эдийн засгийн үндэслэлтэй диспетчерийн зохицуулалтыг хөхиүлэн дэмжинэ
- Боломжийн зардлаар, бага эрсдэлтэйгээр хэрэгжинэ
- Зах зээлийн өөрчлөлт шинэчлэлийн суурь болохоос гадна Зах зээлийн дүрэм, Нэгдсэн сүлжээний дүрэм болон цахилгаантай холбоотой Засгийн газрын бодлогын бусад баримт бичгүүдийг боловсруулах загвар болно

Шинэ зах зээлийн 100 хувийн оноолтын үеийг 2010 оны 1 дүгээр сард хэрэгжүүлж дуусах, харин зах зээлийн өрсөлдөөнт үеийг Эрчим хүчний хуулинд өөрчлөлт оруулалгүйгээр 2013-2014 онд дуусгах боломжтой. Гэхдээ уг хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах нь Засгийн газар, ЭХЗГ-ын шинэ зах зээлийг амжилттай хэрэгжүүлэх чадавхийг сайжруулахаас гадна тарифын төлөвлөгөөг тодорхой болгох мөн Засгийн газар, ЭХЗГ-ын үүрэг, хариуцлагыг илүү нарийвчлан тогтооход чухал юм.

“Монгол таны дараагийн адал явдал” уриатай кампанит ажил олон улсын зах зээл дээр эхэллээ

“Монгол таны дараагийн адал явдал” уриан дор Монгол улсыг дараагийн адал явдалт орноор сурталчлах арга хэмжээг энэ оны 10 дугаар сарын 21-25 хооронд Норвеги улсад зохиогдсон АТТА-ийн Адал явдалт аяллын дэлхийн дээд хэмжээний уулзалт болон Лондон хотноо 11 дүгээр сарын 10- 13 өдрүүдэд болсон 2008 оны Дэлхийн Аялал Жуулчлалын үзэсгэлэн яармагийн үеэр тус тус зохион байгуулав.



Уг төслийн аялал жуулчлалын зөвлөх Б.Индраа АТТА-ийн арга хэмжээний үеэр зохион байгуулагдсан хэлэлцүүлэгт зочноор оролцож сонирхсон асуултанд хариулав. Эхний хэлэлцүүлэг *Earthwatch* институтын төлөөлөгчидтэй болсон бөгөөд Монголын шувууны төрлөөр нарийвчилсан судалгаа хийх, аль нэг баруун аймагт шувуу судлалыг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх мөн Баруун Монголын соёлын өв уламжлалыг хамгаалах зорилгоор Ховд аймгийн Хойд цэнхэр агуйн сүг зурагнуудыг сэргээн засварлах талаар ярилцаж, санал солилцжээ. Үүнээс гадна *World Nomads*-ын төлөөлөгчидтэй уулзаж, аялал жуулчлалыг хөгжүүлэхийн зэрэгцээ орон нутгийн иргэдийн амьжиргааг сайжруулах зорилгоор тус группээс хэрэгжүүлж буй олон нийтэд түшиглэсэн “Footprints” төслийн талаар ярилцлаа.

АТТА -ийн Адал явдалт аяллын дэлхийн дээд хэмжээний уулзалтын үеэр зохион байгуулагдсан “Монгол таны дараагийн адал явдал” уриатай арга хэмжээний дараа ҮАЖБ, МАЖХ, БОАЖЯ, МИАТ компани болон хувийн таван тур операторуудад Лондон хотноо 11 дүгээр сарын 10- 13

өдрүүдэд болсон 2008 оны Дэлхийн Аялал Жуулчлалын үзэсгэлэн яармагт оролцоход тус төслөөс туслалцаа дэмжлэг үзүүлсэн болно. Тухайлбал, монголын төлөөлөгчдийн үзэсгэлэнгийн талбайг янзлаж байрлуулах, сурталчилгааны CD гаргах, Монголын тухай презентаци тавихад туслав. Монгол Улсаас Умард Ирланд Их Британийн Нэгдсэн Вант Улсад суугаа элчин сайд, БОАЖЯ-ны аялал жуулчлалын газрын дарга болон хувийн тур операторуудын тавьсан презентациудыг уг төслийн аялал жуулчлалын зөвлөх Б.Индраа удирдан явууллаа.

“Чингис хаан: амьдрал, үхэл, хойд нас” номын зохиогч ноён Жон Мэн Монголын тухай презентацийн үеэр үг хэлсэн нь чухал үйл явдал болов. Түншүүдтэйгээ байгуулсан гэрээгээ дахин шинэчлэх, монголын инбаунд аялал жуулчлалыг сурталчлах бизнесийн шинэ түншүүдтэй шууд холбоо тогтоох, Хөтөч-тайлбарлагч нарын институттэй хэлэлцээр хийх ажлыг санаачлахад ЭЗБШӨЧ төслөөс дэмжлэг үзүүлэв. Баруун аймгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг сурталчлахад чухал үүрэг гүйцэтгэх орон нутгийн иргэд, жуулчны салбарын үйлчилгээний хүмүүсийг бэлтгэж сургах талаар Хөтөч-тайлбарлагч нарын институттэй хамтран ажиллах бололцоотой юм.

Ирэх саруудад “Монгол таны дараагийн адал явдал” кампанит арга хэмжээг Нью-Йорк Таймсын Аялал жуулчлал худалдааны шоу, Берлин хотноо зохиогдох Олон улсын аялал жуулчлалын ИТВ үзэсгэлэн яармаг, уулзалт, хурлын үеэр сурталчлахаас гадна аялал жуулчлалын томоохон зах зээл дээрх аялал жуулчлалын тэргүүлэх сонин хэвлэлд нийтлэл гаргах, маркетингийн үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, төрөлжсөн тур операторуудтай холбоо тогтоох, аялал жуулчлалын гэрчилгээ, шагнал авах өргөдөл өгөх зэрэг ажлуудыг төлөвлөөд байна.

Энэхүү цуврал нь ЭЗБШӨЧ төслийн үйл ажиллагааны сар тутмын цахим хэвлэл юм. Та өөрийн санал бодол, манай цувралыг захиалах буюу захиалгаа цуцлах хүсэлтээ ЭЗБШӨЧ төслийн цуврал хариуцсан эрхлэгчид дараахь хаягаар ирүүлнэ үү.
И-мэйл fbertoli@eprc-chemonics.biz, факс: (976-11) 32 78 25.